

2004 ОНЫ САНХҮҮГИЙН ЖИЛД МЯНГАНЫ СОРИЛТЫН ДАНСНААС ТУСЛАЛЦАА АВАХ САНАЛ БОЛОВСРУУЛАХАД ЗОРИУЛСАН УДИРДАМЖ

2004 оны санхүүгийн жилд Мянганы Сорилтын Сангаас (цаашид МСС гэх) туслалцаа авах болзол хангасан орнуудыг 2004 оны тавдугаар сард зарласны дараа Мянганы Сорилтын Корпорацид (цаашид МСК гэх) санхүүжилт хүссэн саналаа ирүүлэхийг МСК-ийн Захирлуудын Зөвлөл хүсэх юм. Болзол хангасан орнуудад саналаа боловсруулахад нь дараах удирдамж тус болно.

Мянганы Сорилтын Сангийн Үндсэн Бодлого

МСС нь хэд хэдэн гол зарчим, түүний дотор "тогтвортой өсөлтөд чиглэсэн, тухайн орон өөрөө өмчилсөн, бүх талуудыг хамруулсан, хариуцлагын тогтолцоо, үр дүнг голчилсон байх" зарчмуудад суурилсан хамтын ажиллагаа бөгөөд МСС-ийн хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх бүх шатанд эдгээр зарчмыг баримтлах юм. Аливаа улсын эдийн засгийн хөгжилд тухайн улсын өөрийн бодлого, байгууллагууд гол үүрэгтэй байдаг болон хөгжлийн зорилго, бодлого, үйл ажиллагаагаа тус орон өөрөө "өмчилдөг" байх нь чухал болохыг нотолсон хөгжлийн талаарх сүүлийн үеийн судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд МСС нь үйл ажиллагаагаа түшиглэж байна. Иймээс тухайн орон ирүүлж буй санал дотроо хөгжлийн тодорхой зорилго, цаашид үргэлжлүүлэх бодлогын шинэчлэл, эдийн засгийн өсөлт буй болгох, ядуурлыг бууруулахад үндсэн үүрэг гүйцэтгэх байгууллагуудаа бэхжүүлэх тухай төлөвлөгөө оруулж өгөхийг МСС нь хүсэх болно. Түүнчлэн МСС-ийн үр бүтээлтэй хөтөлбөр нь хэмжиж болохуйц зорилт, үр дүнгийн төлөө хүлээх хариуцлага болон санхүүгийн үр бүтээлтэй хяналт шаардагдах болно гэдгийг МСС хүлээн зөвшөөрдөг.

Хөгжлийн туслалцааны хөтөлбөрүүд үр дүнтэй байхын тулд тухайн оронд өргөн дэмжлэг авч байх ёстой гэж үздэг учраас МСС-ийн хөтөлбөрүүдийг төр, засгийн, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагууд хамтран хэрэгжүүлэх ёстой гэж МСК үздэг. Үүний нэгэн адил аливаа санал бүрийг боловсруулахдаа төр засгийн сонирхлыг хувийн хэвшил болон иргэний нийгмийн сонирхолтой нийцүүлэн нээлттэй зөвлөлдөх үйл явцын үр дүнг тусгасан байх нь зүйтэй.

МСС-ийн Гэрээ

МСС-ийн хөтөлбөрийг санхүүжүүлэхэд санхүүжилт хүсэгч орон болон МСК-ийн хооронд тодорхой Гэрээг амжилттай хэлэлцэн тохиролцож байгуулсан байх ёстой. Гэрээнд онцлог асуудлуудыг ямар түвшинд тусгаж өгөх нь улс орон бүрийн хувьд өөр байх талтай. Хэдийгээр зарим тохиолдолд Гэрээ нь өөртөө зарим асуудлыг нарийн тодорхой (тухайлбал, санхүү, нягтлан бодох, тайлагнах, мониторингийн хяналт ба үнэлгээ зэргийг) тусгаж болох боловч ихэнх тохиолдолд Гэрээнд ерөнхий зорилт, хөтөлбөр хэрэгжүүлэх стратегийг тусгаж, харин Гэрээний бүтцийн хүрээнд дараа нь байгуулагдах хэрэгжүүлэлтийн хэлэлцээрт төслийн төлөвлөгөөг оруулж өгөх нь зүйтэй гэж МСК үзэж байна. Аль ч тохиолдолд, хөтөлбөрийн тодорхой зорилго, зорилтыг МСС-ийн хөтөлбөрийн санал бүрт аль болох дэлгэрэнгүй, нарийвчлан зааж өгөх хэрэгтэй.

МСС-аас Туслалцаа Хүсэх Санал

Тухайн оронд хэрэгжүүлэхээр санал болгож буй хөтөлбөрийн шинж чанар, цар хүрээнээс шалтгаалаад саналын хэлбэр, агуулга өөр өөр байна гэдгийг МСК хүлээн зөвшөөрнө. Үүний зэрэгцээ, тухайн орны хөтөлбөрийн тодорхой асуудлууд болон Гэрээний нөхцлийг МСК болон санхүүжилт хүсэгч орнууд харилцан санал солилцох, тохиролцох замаар аажмаар боловсруулах хэрэгтэй болно. Гэвч, энд хавсаргасан саналын жишээнд харуулснаар, анх санал боловсруулж хүргүүлэхдээ дор дурдсан мэдээллийг аль болох дэлгэрэнгүй оруулж өгөхийг бид санхүүжилт хүсэгч орнуудад зөвлөж байна:

- **Зорилт/Зорилго**
 - Саналын хураангуй, үүний дотор танай улсын эдийн засгийн өсөлт болон ядуурлыг бууруулах талаар баримталж буй ерөнхий стратеги, тус улсад эдийн засгийн өсөлт буй болгох, ядуурлыг бууруулахад учирч буй гол саад бэрхшээлүүд, эдгээр саад бэрхшээлийг арилгахад МСС-ийн туслалцааг танай орон хэрхэн ашиглахаар төлөвлөж байгаа;
 - Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй Гэрээний хугацаанд хүрвэл зохих тодорхой зорилтууд, түүний дотор нэн тэргүүний ач холбогдол бүхий салбар (priority area) болон эцсийн ашиг тусыг хүртэгсдийг тодорхойлох;
 - Гэрээний санал болгож буй хугацаа (5 жилээс илүүгүй байх).

- **Үндэслэл**
 - Танай санал болгож буй хөтөлбөр нь яагаад эдийн засгийг хөгжүүлэх болон ядуурлыг бууруулахад нэн тэргүүний ач холбогдолтой болох, МСС-аас хамгийн түрүүнд туслалцаа авах шаардлага хэрэгцээг тайлбарлах;
 - Энэхүү хөтөлбөр яагаад амжилттай хэрэгжих өндөр боломжтой болохыг тайлбарлаж, үндсэн бололцоо болон эрсдэлийн хүчин зүйлсийг тодруул; Хэрэв боломжтой бол, танай орон болон өөр улсад хэрэгжиж буй туслалцааны ижил төстэй бусад санаачилгатай тухайн хөтөлбөрөө харьцуулж үзүүл.

- **Зөвлөлдөх ажиллагаа** - Санал боловсруулахдаа төр, олон нийт, хувийн хэвшлийнхэнтэй зөвлөлдөх ажиллагааг хэрхэн ашигласнаа тайлбарла.

- **Хэрэгжилт** - Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий стратеги, түүний дотор:
 - **Бүтэц зохион байгуулалтын тогтолцоо** - Хөтөлбөрийн удирдлага, төсөл, үйл ажиллагааг хэрхэн батлах, санхүүгийн ерөнхий менежмент, хөтөлбөрийн хяналт, үнэлгээ, МСК-тай үйл ажиллагаагаа зохицуулах, түүний дотор, хэрэв хамааралтай бол, хөтөлбөр хэрэгжүүлэхэд иргэний нийгэм болон хувийн хэвшлийнхний үүрэг роль ямар байхаар төлөвлөж буй зэргийг тусгана.
 - **Хандивлагчдын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах** - Санал болгож буй нэн тэргүүний ач холбогдолтой салбарт ажиллаж буй бусад хандивлагчдын үйл ажиллагаа, МСК-ийн үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах механизмуудыг харуул.
 - **Бодлого** - Тухайн онцлог хөтөлбөрийн тавьсан зорилгод хүрэхэд шаардлагатай гэж танай төр, засгийн газраас үзсэн бодлогын, эрх зүйн болон зохицуулалтын арга хэмжээ, шинэчлэлтийг тайлбарла.

- **Төслүүд** - Бололцоотой бол, гэрээний хүрээнд санхүүжүүлж болох жишээ төслүүдийг тайлбарлаж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх саналаа ирүүлэхийг хүсэх, ирсэн саналыг хянах, батлах зэрэгт үйлчилдэг журам, үйл явцыг харуул.
 - **Өртөг ба санхүүжилт** - МСК, танай төр, засгийн зүгээс болон гуравдахь этгээдүүдээс оруулахаар төлөвлөж буй хувь нэмрийг багтаасан, хөтөлбөрийн хугацааны санхүүгийн төлөвлөгөө боловсруул.
 - **Хяналт тавих, хариуцлага тооцох** - Гэрээний зорилгод хүрэхээр хийж буй ажлын ахицыг хэмжих хяналтын төлөвлөгөө (түүний дотор, боломжтой бол, тоон баримтаар хэмжих үзүүлэлтийг оруулж өгөх), санхүүгийн хариуцлага тооцох төлөвлөгөө, буцалтгүй тусламжийн санхүүжилт хийх болон бараа, үйчилгээ худалдаж авахад нээлттэй, шударга, ил тод байдлыг хангахад чиглэсэн үйл явц зэргийг тус тус тайлбарла.
- **Тогтвортой байдал:** Гэрээ дуусгавар болсны дараа МСС-ийн хөтөлбөрийн олсон ололт амжилтыг хэрхэн цаашид тогтвортой үргэлжлүүлэх талаарх өөрийн орны стратегийг харуулна.
 - **МСС-ийн шалгуурыг байнга хангах талаарх хүчин чармайлт** - МСС-аас гаргасан улс орнуудыг сонгон шалгаруулах шалгуурын дагуу олсон ололт амжилтаа танай орон цаашид үргэлжлүүлэн хангахын тулд хийж байгаа болон хийхээр төлөвлөж буй ажлаа тайлбарла.

Санал хянан шалгаруулах болон дараагийн үе шат

Санхүүжилт авах болзол хангасан орноос санал ирүүлэх нь МСК тухайн оронтой гэрээ байгуулах эсвэл тухайн орны санал болгосон хөтөлбөрийг санхүүжүүлэх явдлын баталгаа болохгүй. МСК саналыг үнэлэхдээ, хэд хэдэн хүчин зүйлс, түүний дотор тус санал болгож буй хөтөлбөр нь эдийн засгийн өсөлт, ядуурлыг бууруулах асуудалтай хэрхэн уялдаж байгаа зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргах юм. Гэхдээ тухайн орноос ирүүлэх эхний саналын чанар нь тухайн оронтой МСК-аас үндсэн асуудлуудаар хэр хурдан хэлэлцэж эхлэх, Гэрээг хэлэлцэн тохирч байгуулах ажлын хурд ямар байх, МСК-ийн Захирлуудын Зөвлөлөөс тусалцаа олгох асуудлыг хэдийд батлах зэрэгт шууд нөлөөлнө.

Шалгарсан орны саналыг хянаж үзсэний дараа МСК нь тус орны томилсон төлөөлөгчтэй дараагийн үе шатыг хэлэлцэхээр холбоо барина. Санал хүргүүлэх болон МСС-ийн хөтөлбөр хэрэгжүүлж эхлэхийн хоорондох үйл явц нь хэд хэдэн үе шаттай байх бөгөөд энэ нь орон бүрийн хувьд өөр байх болно гэдгийг шалгарсан орнууд ойлгох ёстой. Жишээлбэл, зарим тохиолдолд, саналыг цаашид боловсронгуй болгох зорилгоор тухайн улсад тохирохуйц техникийн тусалцааны хэлбэрийг тодорхойлоход нь МСК-аас туслах явдал дараагийн үе шатыг бүрдүүлж болно. Өөр бусад тохиолдолд, санал хангалттай сайн боловсруулагдаж улмаар хөтөлбөрийн зорилт, төсөв, санхүүгийн болон хөтөлбөрийн талаар хариуцлага тооцох явдал, санал болгож буй хөтөлбөртэй холбогдсон бусад асуудлаар МСК тодорхой хэлэлцэж эхлэх үндэс суурийг тавьсан байж болно. МСК болон шалгарсан орон нь тус улсад хэрэгжүүлэх хөтөлбөрийн үндсэн хэмжүүрүүдийн талаар ерөнхийдөө харилцан зөвшилцөөд бэлэн болсон тохиолдолд бид Гэрээг эцсийн байдлаар хэлэлцэж (үүнийг МСК-ийн Зөвлөл батлах ёстой), улмаар хөтөлбөр хэрэгжүүлэхэд бэлдэж эхлэх юм.

Хэрэв танд санал боловсруулах болон хүргүүлэхтэй холбогдсон ямарваа нэгэн асуулт байвал Шерри Крахам (Sherri Kraham)-тай (703) 875-7323 дугаарын утсаар эсхүл compactguidance@mcc.gov гэсэн цахим шуудангийн хаягаар холбоо барьж болно.

Шалгарсан орнууд саналаа цахим файлын хэлбэрээр Proposals@mcc.gov гэсэн цахим шуудангийн хаягаар болон:

**Millennium Challenge Corporation
Attn: MCA Program Proposals
1000 Wilson Blvd
Suite 1411
Arlington, Virginia 22209**

гэсэн хаягаар шуудангаар илгээж болно

ЭНЭХҮҮ УДИРДАМЖ ЗӨВХӨН МЭДЭЭЛЭХ ЗОРИЛГОТОЙ БӨГӨӨД ЦААШИД МСК-ИЙН ЗҮГЭЭС ҮҮНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ХИЙЖ БОЛНО. ЭНЭХҮҮ УДИРДАМЖ ЭСВЭЛ МСС-ААС ТУСЛАЛЦАА ХҮСЭГЧ САНАЛАА ХҮРГҮҮЛСЭН ЯВДАЛ НЬ ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ БОЛОН АЛИВАА ГУРАВДАГЧ ЭТГЭЭДИЙН ХУВЬД ТУСГАЙЛСАН ДАВУУ ЭРХИЙГ БИЙ БОЛГОХГҮЙ.

Хамгийн сүүлд нэмэлт өөрчлөлт оруулсан өдөр: 4/29/04

МЯНГАНЫ СОРИЛТЫН САНГААС ТУСЛАМЖ ХҮСЭХ САНАЛЫН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГИЙН ЖИШЭЭ

Мянганы Сорилтын Сангаас (цаашид МСС гэх) тухайн оронд хэрэгжүүлэх хөтөлбөр болон үүнтэй холбоотой МСС-ийн Гэрээг эцсийн байдлаар хэлэлцэн тохирохоос өмнө Мянганы Сорилтын Корпораци (цаашид МСК гэх) болон санал хүргүүлэгч орон хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий зорилт, стратегийн талаар тохиролцсон байх шаардлагатай. МСС-ийн Гэрээ нь түүнд хавсаргасан хөтөлбөрийн баримт бичиг, тус Гэрээний хүрээнд байгуулсан төсөл хэрэгжүүлэх тухай бусад хэлцлүүдийн хамт нэн тэргүүний томоохон зорилтууд ба үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй (тухайлбал, санхүүгийн, нягтлан бодох бүртгэлийн, тайлагнах, мониторингийн хяналт ба үнэлгээ хийх төлөвлөгөө зэрэг) мэдээллийг хөтөлбөрийн хэмжээнд болон тодорхой төсөл, үйл ажиллагааны хэмжээнд тус тус зааж өгнө.

Тухайн оронд хэрэгжүүлэхээр санал болгож буй хөтөлбөрийн шинж чанар, цар хүрээндээ шалтгаалаад саналын хэлбэр, агуулга өөр өөр байна гэдгийг МСК хүлээн зөвшөөрнө. Нөгөөтэйгүүр, тухайн орны хөтөлбөрийн дэлгэрэнгүй асуудлууд болон Гэрээний нөхцлийг МСК болон санхүүжилт хүсэгч орнууд яваандаа харилцан санал солилцох, тохиролцох замаар боловсруулах хэрэгтэй болно. Гэвч, анх санал боловсруулж хүргүүлэхдээ санал болгож буй хөтөлбөрийн талаар аль болох дэлгэрэнгүй мэдээлэл оруулж өгөхийг бид санхүүжилт хүсэгч орнуудад зөвлөж байна. Эрх зүйн хувьд заавал байх ёстой нөхцлөөс (тухайлбал, МСС-ийн туслалцаанд татвар хураахыг хориглох гэх мэт) гадна Гэрээ болон хөтөлбөрийн бусад холбогдох баримт бичиг, хэлэлцээрт эцсийн байдлаар орох зарим бүрэлдэхүүн хэсэг заалтын жишээг дор харуулав. Тиймээс эдгээрийг МСС-аас туслалцаа хүсэх саналд мөн оруулж болох юм.

1. Зорилт ба Зорилго:

- a. **Саналын хураангуй:** Саналын хураангуй, үүний дотор танай улсын эдийн засгийн өсөлт болон ядуурлыг бууруулах талаар баримталж буй ерөнхий стратеги, түүнчлэн МСС-ийн туслалцаа авахыг хүсэж буй хөгжлийн хөтөлбөрүүд (цаашид Хөтөлбөр гэх). Хураангуйд тус улсад эдийн засгийн өсөлт буй болгох, ядуурлыг бууруулахад учирч буй гол саад бэрхшээлүүд, эдгээр саад бэрхшээлийг арилгахад МСС-ийн туслалцааг танай орон хэрхэн ашиглахаар төлөвлөж байгааг мөн дурдаж болох юм.
- b. **Нэн тэргүүнд авч үзэхээр санал болгож буй салбарууд:** Хөтөлбөрийн анхаарлын төвд байвал зохино гэж үзэж санал болгож буй нэн тэргүүний салбарууд (жишээ нь, Боловсрол, Эрүүл мэнд, Хөдөө аж ахуй, Санхүүгийн салбарын хөгжил, Хувьчлал, Эрх зүйн шинэтгэл, Шүүхийн шинэтгэл, гэх мэт). Дээр дурдсан салбарууд зөвхөн жишээ бөгөөд МСК-ийн зүгээс бодлогын хувьд илүүтэй авч үзэх салбарууд биш, мөн үүнээс өөр салбарыг хязгаарласан хэрэг бус гэдгийг анхаарна уу.
- c. **Хүрэхээр төлөвлөж буй зорилтууд:** Дээр дурдсанаар нэн тэргүүнд авч үзэх салбар бүр дээр (i) хэрэгжүүлэхээр төлөвлөж буй, Гэрээний хугацаанд хүрвэл зохих онцлог зорилтууд; (ii) эдгээр стратеги зорилтууд нь танай оронд эдийн засгийн өсөлт буй болгох, ядуурлыг бууруулахтай хэрхэн уялдаатай болох; (iii) эцсийн ашиг тусыг хүртэгсдийг хэрэв бололцоотой бол орлогын түвшин, хүйс, насаар нь ангилж харуулах.

2. **Үндэслэл:** Танай санал болгож буй хөтөлбөр яагаад эдийн засгийг хөгжүүлэх болон ядуурлыг бууруулахад нэн тэргүүний ач холбогдолтой бөгөөд МСС-аас хамгийн түрүүнд туслалцаа авах шаардлага хэрэгцээг тайлбарлах. Үндэслэлд, энэ хөтөлбөр яагаад амжилттай хэрэгжих өндөр боломжтой болох, түүний дотор үндсэн бололцоонууд болон эрсдэлийн хүчин зүйлсийг тайлбарлаж болох юм. Түүнчлэн, хэрэв боломжтой бол, тухайн хөтөлбөр танай орон болон өөр улсад хэрэгжиж буй туслалцааны ижил төстэй бусад санаачилгатай харьцуулахад ямар түвшинд байхыг дурдаж болох юм.
3. **Зөвлөлдөх ажиллагаа** - Санал боловсруулахдаа төр, олон нийт, хувийн хэвшлийнхэнтэй зөвлөлдөх ажиллагааг хэрхэн ашигласнаа тайлбарлах, түүний дотор (i) тус саналд орон нутгийн түвшинд амьдарч буй хот, хөдөөгийн ядуучууд, ялангуяа эмэгтэйчүүдийн санаа бодлыг хэрхэн тусгасан, хувийн хэвшлийн болон сайн дурын байгууллагууд, бизнесийн хүрээнийхэнтэй танай төр, засгийн байгууллагууд хэрхэн зөвлөлдсөн (ii) санал боловсруулахад томоохон хувь нэмэр оруулсан төрийн болон төрийн бус байгууллага, тэдгээрийн албан тушаалтнуудын нэрсийн жагсаалт зэргийг тусгана.
4. **Хэрэгжилт** - Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий стратеги, түүний дотор хөтөлбөрийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд:
 - a. **Бүтэц зохион байгуулалтын тогтолцоо** - Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын ерөнхий тогтолцоо /байгууллагууд, үүрэг роль г.м.л, түүний дотор танай төр, засгийн байгууллага, МСК болон гуравдахь этгээдээс дараах асуудлаар хүлээх үүрэг ролийг тодорхойлох. Үүнд: (i) төслийн болон тодорхой үйл ажиллагааны түвшинд санал хүлээж авах, хянах, сонгон шалгаруулах үйл явцыг удирдах; (ii) Хөтөлбөрийн төсөв боловсруулах, нягтлан бодох бүртгэлийг хэрэгжүүлэх, мөнгөн санд хяналт тавих болон санхүүгийн ерөнхий хяналт тавих; (iii) Хөтөлбөрийн үйл явцад хяналт тавих, үнэлгээ гаргах явдал тус тус болно. Хэрэв хамааралтай бол, хөтөлбөрийн хэрэгжилтэнд иргэний нийгэм болон хувийн хэвшлийнхний үүрэг роль ямар байхаар төлөвлөж буйг энэ хэсэгт тусгаж болох юм.
 - b. **Хандивлагчдын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах** - Дээр дурдсанаар нэн тэргүүнд авч үзэх салбар бүр дээр хандивлагчдын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үйл явцыг тайлбарлах, түүний дотор (i) дээр дурдсан нэн тэргүүний салбарт хөгжлийн туслалцаа үзүүлсэн бусад хандивлагчдаас сүүлийн жилүүдэд оруулсан хувь нэмэр; (ii) эдгээр нэн тэргүүний салбар, зорилтуудтай холбоотой, одоо хэрэгжиж буй болон урьд нь хэрэгжсэн төслүүд ямар үр дүнтэй байсан; (iii) Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд бусад хандивлагчдын туслалцааны үйл ажиллагаатай хэрхэн зохицуулахыг дурдана.
 - c. **Бодлого** - Тухайн онцлог хөтөлбөрийн тавьсан зорилгод хүрэхэд шаардлагатай гэж танай төр, засгийн газраас үзсэн бодлогын, эрх зүйн болон зохицуулалтын арга хэмжээ, шинэчлэлтийг тайлбарлах (жишээлбэл, төр, засгийн байгууллагуудын санхүүгийн менежментийн системийг орчин үеийн түвшинд гаргах; өмчийн талаарх болон татварын хуулийг сайжруулах гэх мэт), түүний дотор МСК эдгээр чиглэлээр ямар хэлбэрийн туслалцаа үзүүлж болохыг тус тус дурдана.

- d. **Төслүүд** - Боллоцотой бол, Гэрээний хүрээнд санхүүжүүлж, хэрэгжүүлж болох жишээ төслүүдийг тайлбарлаж, хэрэв тодорхой бол, эхний ээлжинд хэрэгжүүлэхээр санал болгож буй төслүүдийг ерөнхийд нь дурдах. Мөн, хэрэв хамааралтай бол энэ хэсэгт дараах зүйлсийг тодруулж зааж өгч болно: (i) Хөтөлбөрийн хүрээнд тавьсан зорилтыг хэрэгжүүлэх хөтөлбөрийн саналуудыг (санал ирүүлэхийг хүссэн, бие даан ирснээс үл хамааран) болон хөтөлбөрийн хэрэгжилтэнд хэрэглэх бараа, үйлчилгээ худалдан авах явцад хэрэглэдэг нээлттэй, шударга, өрсөлдөөнт журам, үйл явц; (ii) аливаа санал ирүүлэх хүсэлт гаргах, ирсэн саналыг хянах, сонгон шалгаруулахад танай төр, засгийн байгууллага, МСК болон гуравдагч этгээдүүдийн үүрэг роль ямар байхыг хэрхэн төсөөлж байгааг дурдах.
- e. **Өргөг ба санхүүжилт** - Санал болгож буй хөтөлбөрийн бүрэн хугацааны санхүүгийн төлөвлөгөө, үүний дотор, жишээлбэл : (i) Хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, үр дүнд хүрэхийн тулд гарах зардлын үндэслэл болон холбогдох баримтын бүрдүүлэлт (ii) өөрчлөлт гараагүй үеийн төсвийн мэдээллийн үндэслэл; (iii) МСК, танай төр, засгийн зүгээс болон гуравдахь этгээдүүдээс (жишээлбэл, хандивлагчдаас) оруулахаар төлөвлөж буй хувь нэмэр; (iv) Хөтөлбөрийн хэрэгжилтийн ололт амжилтыг харгалзсан жил жилээр харуулсан төсвийн ашиглалтын төлөвлөгөө.
- f. **Мониторингийн хяналт, хариуцлагын тогтолцоо:**
- i. **Санхүүгийн хариуцлага тооцох төлөвлөгөө:** Гэрээнд заасны дагуу зарцуулагдах санхүүжилтад тавих санхүүгийн хариуцлага хяналтын төлөвлөгөөг тайлбарлах, түүний дотор, жишээлбэл: сангийн хяналт, баримт бүрдүүлэлт, албан тушаалын зааг ялгаа, дотоодын хяналт, нягтлан бодох бүртгэлийн стандарт, систем, шаардлагатай тайланг цаг хугацаанд нь үнэн зөв гаргах чадвар, санхүүгийн бүх мэдээллийг олон түмэнд хүртээлтэй байлгах талаарх бодлого, мөнгөний менежментийн арга барил, нийлүүлэгчдэд төлбөрийг цаг хугацаанд нь хийх, худалдан авах, гэрээ байгуулах арга барил, хараат бус аудиторуудын үүрэг роль зэргийг дурдана. Хэрэв хамааралтай бол, төр, засгийн байгууллагуудын санхүүгийн менежментийг сайжруулах талаарх аливаа төлөвлөгөөгөө тайлбарлана.
- ii. **Мониторингийн хяналт ба үнэлгээний үйл явц:** Хөтөлбөрийн зорилтод хүрэхийн тулд хийж буй ажлын ололт амжилтыг хэрхэн үнэлэх талаар тайлбарлах ба үүнд, жишээлбэл, (i) санал болгож буй зорилтод хүрэх явдлыг хэрхэн хэмжих; (ii) Хөтөлбөрийн зорилтод хүрэхээр гаргасан ололт амжилт бүрийг тогтмол хэмжиж байх ба дунд хугацаанд харагдах үр дүн, үзүүлэлтийг санал болгох; (iii) Хөтөлбөр эхлэх үеийн байдлыг харуулсан өөрчлөлтийн өмнөх үнэлгээ (эсвэл ийм өөрчлөлтийн өмнөх үнэлгээг тогтоох төлөвлөгөө) хөтөлбөрийн хүрэхээр төлөвлөж буй зорилт, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг санал болгох (iv) хэрэгжилтийн ахицийн талаарх мэдээллийг хэрхэн цуглуулж, баталгаажуулах гэж байгаа талаарх төлөвлөгөө зэргийг тус тус дурдана. Хэрэв тодорхой төсөл санал болгож байгаа бол энэ хэсэгт хөтөлбөрийн зорилт, дунд хугацаанд харагдах үр дүн гаргахад хувь нэмэр оруулахуйц арга хэмжээ, үзүүлэлтийг тодорхойлж болно. (Хавсралт А-д харуулснаар нэгэн хийсвэр Хөтөлбөрийн зорилт, үр

дүнгийн үзүүлэлтийг жилээр, зорилт бүр дээр гаргасан ололт амжилтыг хэмжих үзүүлэлтээр тус тус харуулав).

5. **Тогтвортой байдал:** Гэрээ дуусгавар болсны дараа МСС-ийн хөтөлбөрийн олсон ололт амжилтыг хэрхэн цаашид тогтвортой үргэлжлүүлэх талаарх танай орны стратеги
6. **МСС-ийн шалгуурыг байнга хангах талаарх хүчин чармайлт** - МСС-аас гаргасан улс орнуудыг сонгон шалгаруулах шалгуурын дагуу олсон ололт амжилтаа танай орон цаашид үргэлжлүүлэхийн тулд хийж байгаа болон хийхээр төлөвлөж буй ажлаа тайлбарла. Дээрх шалгуурыг "2004 оны санхүүгийн жилд Мянганы Сорилтын Сангийн туслалцаа авахаар нэр дэвшсэн орнуудыг сонгон шалгаруулах шалгуур болон аргачлал" хэмээх илтгэлд дурдсан байгаа. Илтгэлийг (http://www.mcc.gov/Documents/methodology_report.pdf) хаягтай вэбсайтаас олж болно.
7. **МСК-ийн харгалзаж үзэх бусад хүчин зүйлс:** Үүнд бусад хүчин зүйлсийг тайлбарлах буюу тухайн саналыг дэмжсэн холбогдох материал, баримт бичиг, жишээлбэл, судалгаа, тойм, одоо хэрэгжиж байгаа буюу өмнө нь хэрэгжсэн хөтөлбөрийн үнэлгээ зэрэг орж болно.
8. **Засгийн газрын төлөөлөл:** Танай Засгийн газрыг төлөөлөн Гэрээг хэлэлцэн тохирох үндсэн үүрэг бүхий төлөөлөгч (эсхүл төлөөлөгчид), нэр, албан тушаал, байгууллага болон холбоо барих хаяг.
9. **Ил тод байдал:** Гэрээ болон Хөтөлбөрийн зорилгод хүрэхээр хийж буй ажлын ахицыг танай улсын олон нийгэд хэрхэн хүргэж, танилцуулах талаарх та бүхний төлөвлөгөө

Хавсралт А: Зорилт ба үр дүнгийн хүснэгт

Тэмдэглэх нь: Зорилт болон үр дүнгийн хүснэгтийн жишээг дор толилуульж байна. Энэ нь зөвхөн үзүүлэнгийн шинжтэй бөгөөд нэн тэргүүний салбарыг санал болгох буюу тодорхой үзүүлэлтүүдийг хэрэглэхийг зөвлөсөн хэрэг биш гэдгийг анхаарна уу.

Нэн тэргүүний салбар 1: Боловсрол

<u>Хөтөлбөрийн зорилт</u>	<u>Үзүүлэлт</u>	<u>Эхлэх үеийн байдал</u>	<u>1-р жил</u>	<u>2-р жил</u>	<u>3-р жил</u>	<u>4-р жил</u>
Эдийн засгийн өсөлтөд саад болж буй гол зүйлүүдээс Хөтөлбөрийн зорилт гарч ирнэ. ЖИШЭЭ: Ирээдүйн ажиллах хүчний мэдлэг, чадварыг дээшлүүлэх, эсвэл хөдөө орон нутагт амьжиргааны түвшинг дээшлүүлэх	Хэрэв бололцоотой бол салбарын түвшний үзүүлэлтийг хэрэглэ. ЖИШЭЭ: Сургуулийн насны хүүхдийн дундах бичиг үсэг тайлагдсан байдал, эсвэл фермерийн орлого г.м.	X%				Y%
<u>Дунд хугацааны үр дүн</u>	<u>Үзүүлэлт</u>	<u>Эхлэх үеийн байдал</u>	<u>1-р жил</u>	<u>2-р жил</u>	<u>3-р жил</u>	<u>4-р жил</u>
Бие даасан төсөл, үйл ажиллагааны үр дүн, гарцын нийлбэрийг дунд хугацааны үр дүн гэнэ. ЖИШЭЭ: Бага сургуульд явж буй сургуулийн насны хүүхдийн хувийг нэмэгдүүлэх г.м.	ЖИШЭЭ: Сургуульд хамрагдсан байдал ба хичээлийн ирц	X%	X%	Y%	Z%	Etc.
Хөтөлбөрийн саналд дурдах дунд хугацааны үр дүнгийн тоо нь тухайн санал болгож буй салбарын онцлогоос шалтгаална. 2-р ЖИШЭЭ: Багш нарын ур чадвар дээшилсэн байна.	ЖИШЭЭ: Багш нарын тестийн оноо	X%	X%	Y%	Z%	Etc.

Тодорхой төсөл санал болгож байгаа бол гарц, үйл ажиллагаагаа үр дүн, зорилттой уялдуулсан диаграм оруулж болно:

<u>Дунд хугацааны үр дүн</u>	<u>Үзүүлэлт</u>	<u>Эхлэх үеийн байдал</u>	<u>1-р жил</u>	<u>2-р жил</u>	<u>3-р жил</u>	<u>4-р жил</u>
Үр дүн бүр дотроо түүний амжилтад нөлөөлөх нэг буюу түүнээс дээш гарцын үзүүлэлттэй байна. ЖИШЭЭ: Багш нарыг сургаснаар тэдний ур чадвар дээшилсэн байна.	ЖИШЭЭ: Багш нарын тестийн оноо	X%				X%
<u>Гарц</u>	<u>Үзүүлэлт</u>	<u>Эхлэх үеийн байдал</u>	<u>1-р жил</u>	<u>2-р жил</u>	<u>3-р жил</u>	<u>4-р жил</u>
ЖИШЭЭ: Багш нарыг сургах	ЖИШЭЭ: Курс төгссөн багш нарын хувь	X%	X%	Y%	Z%	Etc.

Нэгдүгээр зүйлд заасан нэн тэргүүний салбар бүр дээр ийм хүснэгтийг оруулж өг.